



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/144

Есөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн, 50.1.1 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь хэсгүүд, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам" А/254 дүгээр тушаалаар баталсан журмыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын урсгал төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Ундрага-Алтай аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт Иргэдийг ундны усаар хангахад шаардагдах ариутгалын бодис, кальцийн гипохлорид нийлүүлэх худалдан авах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга	Г.Болдбаатар	(Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Л.Оюундарь	(Хөндлөнгийн төлөөлөл) (тохиролцсон)
Нарийн бичиг:	Ч.Мэндбаяр	(Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Г.Болдбаатар)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

8200010311

C:My document ZAX A-4